



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 401

Ховд

“2025 оныг баялаг бүтээгчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэд, малчид, тариаланчдыг дэмжих жил” болгон зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.16, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Хоёрдугаар хуралдааны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын “Хурдтай хөгжлийн зам” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эдийн засгийн өсөлтийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оныг “Баялаг бүтээгчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэд, малчид, тариаланчид”-ыг дэмжих жил болгон зарласугай.

2. Баялаг бүтээгчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэд, малчид, тариаланчдыг дэмжих бодлого боловсруулж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Уртнасан, Л.Энхбаяр) нарт, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Сандагсүрэн), Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга (Л.Билэгдэмбэрэл) нарт үүрэг болгосугай.

3. Баялаг бүтээгчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэд, малчид, тариаланчдад хуулийн хүрээнд зөвлөн тусалж, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Уртнасан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0026

Zah A/GC Kh